



Фокус бүлгийн ярилцлага

Рэймонд Жервейс

2022



Агуулга

Сэдвийн хүрээнд:

- ❖ Мэдээлэл цуглуулах гол арга: Фокус бүлгийн ярилцлага
- ❖ Фокус бүлгийн ярилцлага хийх
- ❖ Фокус бүлгийн аргын давуу сул талууд

Хэзээ, яагаад Фокус бүлгийн ярилцлагыг хэрэглэдэг вэ?

Энэ аргыг олон улсын байгууллага, төрийн бус байгууллагууд, судлаачид төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилгоор мэдээлэл цуглуулах чанарын арга болгон өргөнөөр ашигладаг.

ФБЯ нь ихэвчлэн санал асуулгад өгөгдсөнөөс илүү тодорхой гүнзгийрүүлсэн мэдээлэл, ганцаарчилсан ярилцлагаас илүү бүлэг хүмүүсийн санал бодлыг илэрхийлж өгдөг.

ФБЯ –ын тодорхойлолт

Фокус бүлгийн ярилцлага гэдэг нь нийтлэг шинж чанартай, ихэвчлэн зургаагаас арван хоёр хүнээс бүрдсэн жижиг бүлэг хүмүүсийг модератор удирдан чиглүүлж, бүтэцэлсэн тодорхой сэдвүүдийг ярилцдаг мэдээлэл цуглуулах арга юм.

Модератор нь урьдчилан тодорхойлсон хэлэлцэх асуудлуудыг хөндөж, тэдний санал, байр суурь болон бусад мэдээллийг хайхын тулд чиглүүлэх асуултуудыг ашиглад

ФБЯ нь олон нийтийн хэлэлцүүлэг (нийтлэг сонирхол багатай, массыг хамарсан) болон мэдээллийн бүлгийн ярилцлагаас (Зохион байгуулалтгүй, жижиг бүлэг) ялгаатай.

ФБЯ-хийх алхамууд:

- Алхам 1: Багаа сонгох: чиглүүлэгч тухайн хэлээр чөлөөтэй ярьдаг, тэмдэглэл хөтлөгч, дуу бичигч.
- Алхам 2: Оролцогчдыг сонго. Янз бүрийн аргуудыг хэрэглэж болох ч гол нь оролцогчид нийтлэг шинжтэй байх (хүйс, нас, мэргэжил, гарал угсаа, гэх мэт).
- Алхам 3: Зохион байгуулах газар, цагаа тогтоо. Оролцогчид хэзээ гэдгийг мэдэхээс гадна санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжтой байх.
- Алхам 4: Ярилцлага хийх удирдамж бэлтгэ. Хүн бүр оролцох боломжтой мэдээлэл цуглуулах зорилготой холбоотой хангалттай тооны сэдвүүд бэлтгэх.

Steps in conducting FGDs (continued)

- Алхам 5: Эерэг харилцаа тогтоох замаар ярилцлагыг хийж, нээлттэй асуулт асуух эсвэл оролцогчид хамааралтай сэдвүүдийг хөндөх үедээ үгээ анхааралтай сонгоорой. Ярилцлагын арга техникээ сайтар мэддэг эсэхээ эргэн нэг тунгаагаарай, аль болох олон хүнд санал бодлоо хуваалцах боломжийг олгох хэлбэрээр хэлэлцүүлгийг удирдаарай.
- Алхам 6: Боломжтой бол тэмдэглэл хөтөл.
- Алхам 7: Үр дүнгийн дүн шинжилгээ. Чиг хандлага, ерөнхий дүр зурагт (давтагдах сэдвүүдэд) дүн шинжилгээ хийхийн тулд ярилцлагын тэмдэглэл (фокус бүлэг бүрээс авсан ярилцлагын тэмдэглэл), сэтгэгдэл болон бусад холбогдох мэдээллүүдийг баг нь цуглуулах ёстой.

ФБЯ-ын давуу талууд:

- Энэ нь харьцангуй олон хүнээс үйл ажиллагаа, үйлчилгээ, нөхцөл байдал, туршлагын талаар мэдээлэл цуглуулах, санал бодлоо солилцох үүд хаалгыг нээж өгдөг зардал багатай хэрэгсэл юм.
- Оролцогчид бие биедээ хариулах, санал бодлоо хуваалцах, бие биенийхээ байр суурь, санааг сонсох боломжийг олгодог тул ярилцлага нь интерактив бөгөөд мэдээлэл сайтай байдаг.
- ФБЯ нь цаг хугацаа, нөөцийг хэмнэдэг. Нэг ФБЯ нь нэг эсвэл хоёр цагийн дотор хэд хэдэн оролцогч талуудаас өргөн хүрээтэй, чухал мэдээлэл цуглуулах боломжтой.
- Ганцаарчилсан ярилцлага нь үнэлгээний багт нэг л хүний нөхцөл байдлыг гүнзгийрүүлэн судлах боломжийг олгодог бөгөөд судалгаа нь статистикийн хувьд төлөөлөх түүврээс мэдээлэл цуглуулах боломжийг олгодог бол ФБЯ нь богино хугацаанд хэдэн арван хүнээс ямар ч тусгай тоног төхөөрөмж ашиглахгүйгээр чанарын нарийвчилсан мэдээллийг олж авах үр дүнтэй сонголтыг санал болгодог.

ФБЯ- хэрэглэхэд анхаарах зүйлс:

- Тэд урьдчилан төлөвлөлт шаарддаг бөгөөд энэ нь үргэлж боломжгүй байдаг. ФБЯ нь бүлгээр хийгддэг тиймдээ ч маш их зохицуулалтыг шаарддаг.
- Цуглуулсан мэдээллийг нэгтгэхэд хэцүү байдаг. Цөөн хувьсагч нь статистикийн хэрэгслийг үр дүнтэй ашиглах боломжийг олгодоггүй.
- Чиглүүлэгчийн зүгээс нөлөөлөх эрсдэлд өртөмтгий . Сайтар бодож боловсруулсан ярилцлагын удирдамж, дуу бичлэг, системчилсэн кодчиллол, өгөгдөлд дүн шинжилгээ хийхэд нэгээс олон хүнийг оролцуулах нь мэдээлэл гажуудах эрсдлийг багасгах боловч огт байхгүй болгож чадахгүй.
- Нууцлал хязгаарлагдмал. Гишүүд бүлэгтэй ярилцаж байхдаа хувийн болон нууц мэдээллийг хуваалцах магадлал багатай байж болно. Оролцогчдыг сонгохдоо алдаа гарах нь үр дүнг бууруулж болзошгүй, учир нь жижиг бүлгүүдийн нийгмийн харилцаа, мэдээлэл солилцоо маш нягт байдаг.

• “Баярлалаа”





Mongolia:
Enhancing Resource
Management through
Institutional Transformation

Address: Floor 3, National Times News Tower Khudaldaanii gudamj, Khoroo 1
Chingeltei district, Ulaanbaatar-15160 Mongolia

Phone: 7610-5000